



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/104/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал.....	11-13
4	Аудитлагдсан санхүүгийн тайлан.....	14-19

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН АХМАД
НАСТНЫ АСРАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Д.АМАРСАНАА ТАНАА

2019.01.31 № 2/04

танай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

2518470

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Д.Амарсанаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.01.26–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Асрамжийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.24-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Асрамжийн төв нь “Тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлийн улмаас дэмжлэг үзүүлэх нь тогтоогдсон ахмад настныг асрах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эрхэнд суурилсан асрамжийн үйлчилгээг стандартын дагуу мэргэжлийн түвшинд чанартай баталгаатай, үйлчлүүлэгчийн хэрэгцээ сонирхолд нийцсэн зөв боловсон үйлчилгээ үзүүлэх
- Асруулагчийн өрөө тасалгааны тохижилтийг стандартын дагуу болгож, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг болно.

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Асрамжийн төв удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 43 оноотой үнэлэгдэж, мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Асрамжийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.01 программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт бага гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 185724,6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3714,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	1.30	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.06	
3	Албан шаардлага өгсөн	1	5.90	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	7.26	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Асруулагчаас тушаасан хөрөнгийн төлөвлөлтийг төсвийн бүрэлдэхүүнд оруулж батлах, асруулагчийн мөнгөөр хөрөнгө бэлтгэсэн асуудлыг тодруулан шалгах, худалдан авсан тоног төхөөрөмжийн зах зээлийн үнийг харьцуулан судлах шаардлагатай гэж үзэж байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Асрамжийн төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 98422.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 98079.1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байжээ. Оны эцэст цалингийн зардлыг 2195,0 мянга, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 663,4 мянга, хангамж бараа материалын зардал, хоолны зардлыг нэмж тодотгосон байна.

Өөрийн орлогын төлөвлөгөө байхгүй.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Асрамжийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх жил тус байгууллагад итгэл үзүүлсэн тул аудит хийгдээгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

2018 оны 04 дүгээр сард жирэмсний амралттай Ё.Чулуунцэцэгийг үндсэн ажилтнаар мэдээлснээс ажил олгогчоос 26400 төгрөг илүү шилжүүлсэн, 07 дугаар сард Ч.Бямбатуяад 33626 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2.8.1.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Асруулагчийн 30 хувийн орлогыг төсөвт төлөвлөдөггүй бөгөөд тайлант онд өмнөх оны дутуу төвлөрүүлэлт, 2018 оны төвлөрүүлэлтээр нийт 14,1 сая төгрөг дансанд тушаагдсан байна. Тус орлогын 41,5 хувь буюу 5,9 сая төгрөгөөр байгууллагын даргын өрөөний тохижилтод үндсэн хөрөнгө бэлтгэжээ.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/156 тоот тушаалаар батлагдсан журам тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн захирагч буюу аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга "Баянхонгор эрчим хүч" ЦТХХК-тай 2018.10.05-ны өдөр гэрээ байгуулж, Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгын дотор цахилгаан хангамжийн холболтыг хийж гүйцэтгэх гэрээ байгуулж, 2018.12.07-нд гэрээт ажлын төлбөрт 1,2 сая төгрөг шилжүүлжээ. Уг ажлыг хүлээн аваагүй байхад тайлант жилийн зардлаар бүртгэсэн байна. Оны эцэст хоолны зардлын хэмнэлтээс Ажбид ХХК-д 1034,9 мянган төгрөг шилжүүлж, бараа материалын үлдэгдээр бүртгэсэн. Ажиллагсдын цалингаас суутгасан ҮЭ-ийн татвараас 25,9 мянга, ХХОАТ-т 159,4 мянган төгрөг дутуу шилжүүлсэн атлаа өглөгөөр бүртгээгүй байна. Цалинг програмаар бодоогүйгээс ХХОАТ-ын зөрүү үүсч, ажиллагсдаас илүү татвар суутгаж, 189,3 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд тусгаагүй зөрчил илэрч, санхүүгийн тайланд залруулга хийв.

2. Тайлант хугацаанд худалдан авсан 600,0 мянган төгрөгийн үнэ бүхий цалингийн программыг орлогод аваагүй тул санхүүгийн тайланд алдааг залруулав.

3. Батлагдсан орон тоо 8 ба ажлыг давхар орлон гүйцэтгэж, 7 орон тоогоор ажиллаж, оны эцэст цалингийн хэмнэлтийг бусад зардлын дутагдсан эх үүсвэрт тодотгосон байна. Цалингийн цэстийг давтан тооцоолж, цалингийн зардал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалтай тулган шалгахад эдгээр зардлыг хооронд 208,9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн зөрчил илэрч, санхүүгийн тайланд алдааг залруулав.

Аудитаар илэрсэн алдаа зөрчилд дараахь зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Оны эхэнд санхүүгийн тайлангаар 4681,6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй ба тус үлдэгдлийг анхан шатны баримтгүй 2018 оны 1 сард 4681,6 мянган төгрөгийг зардлаар тайлагнасан, нярвын тайлангаар үлдэгдэлгүй байна. Үүнийг аудитын явцад 2017 оны хүнсний материалын орлого, зарлагыг тулган шалгахад нягтлан бодогч 2017 онд хүнсний материалыг нярвын тайлангаар тухай бүр зардлыг бүртгээгүйтэй холбоотой байна. Хоолны зардлаас 2018 оны 12 дугаар сард 1199,9 мянган төгрөгийг төсвийн захирагчийн шийдвэргүйгээр буяны ажил, шинэ жилийн арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Хоолны зардлыг бараа материалын тайлантай тулган баримтжуулах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Хоолны илчлэг, чанарыг тооцсон хоолны цэсэд тулгуурлан хүнсний материалыг олгож, нярвын бэлтгэсэн бараа материалыг хянаж шалгасны дараа нягтлан бодох бүртгэлд тусгах, хоолны цэсийг бараа материалын тайланд хавсаргаж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.2.1 Илрүүлэлт:

Асруулагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тооцоог хийж шалгахад 2018 онд төвлөрөх ёстой мөнгөнөөс 168,0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлээгүй, он дамжиж 2019.01.08-нд дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 тоот тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна. Мөн асруулагчийн

3.2.2 Эрсдэл: Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/156 тоот тушаалаар батлагдсан “Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.1.10 дахь “Асрамжийн газрын төсвийн хөрөнгө ...Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.8 дахь заалтын дагуу тэтгэвэр авагч ахмад настан,тэтгэврийнхээ 30 хувийг асрамжийн газарт тушаасан хөрөнгө” гэснийг хэрэгжүүлж, төсвийг хөрөнгийн эх үүсвэрт асруулагчийн тушаасан

хөрөнгийг төсвийн бүрэлдэхүүнд оруулж тооцож, асруулагчийн мөнгийг тухай бүр харилцах дансанд төвлөрүүлж байх,

Асруулагчийн тушаасан мөнгийг тухай бүр харилцах дансанд төвлөрүүлж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”-ын 3-т заасны дагуу асруулагчдаас тушаасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.3.1 Илрүүлэлт:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй, санхүүгийн программын шинэчлэлтийг хийгээгүйгээс материал, үндсэн хөрөнгийн дансдын үлдэгдэл зөрүүтэй байна. Энэ нь Толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн байдлын тайлан тооцооллын хувьд алдаатай байх

3.3.3 Өгсөн зөвлөмж: Программын шинэчлэлтийг тухай бүр хийлгэж, санхүүгийн тайлан иж бүрэн, үнэн зөв бэлтгэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,908,907.18</u>	<u>12,434,220.02</u>
33	АВЛАГА	00.00	2,234,960.00
335	Бусад авлага	00.00	2,234,960.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	2,234,960.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,908,907.18	10,199,260.02
354	Хангамжийн материал	25,908,907.18	10,199,260.02
35410	Бичиг хэргийн материал	206,500.00	60,000.00
35420	Аж ахуйн материал	17,220,742.00	10,139,260.00
35440	Түлш, шатах тослох материал	3,800,000.18	00.02
35460	Хүнсний материал	4,681,665.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,376,793,175.04</u>	<u>1,497,192,593.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,376,793,175.04	1,497,192,593.36
392	Биет хөрөнгө	1,376,793,175.04	1,457,266,343.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,516,412,278.00	1,510,299,558.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-273,113,424.03	-157,126,192.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68,998,000.00	68,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41,782,333.52	-52,332,000.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	176,929,429.38	181,310,029.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,097,939.49	-158,347,347.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,898,192.00	113,031,309.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,451,027.30	-48,567,013.57
393	Биет бус хөрөнгө	00.00	39,926,250.00
39301	Програм хангамж	450,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-463,750.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	39,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,402,702,082.22</u>	<u>1,509,626,813.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>503,947.00</u>	<u>374,661.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	503,947.00	374,661.00
413	Өглөг	503,947.00	374,661.00
4136	Бусад өглөг	00.00	189,341.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	189,341.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,402,198,135.22</u>	<u>1,509,252,152.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,402,198,135.22	1,509,252,152.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,976,360.00	66,316,360.00
51101	Өмч: - төрийн	26,976,360.00	66,316,360.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,291,952,958.02	1,285,265,682.82
51210	Өмнөх үеийн үр дүн	1,291,952,958.02	1,291,952,958.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,687,275.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	83,268,817.20	157,670,109.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,402,702,082.22</u>	<u>1,509,626,813.38</u>

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,406,812,397.88	173,624,643.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,307,404,383.88	61,052,285.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,307,404,383.88	61,052,285.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,307,404,383.88	60,713,285.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,307,404,383.88	60,713,285.00
120009	Бусад орлого	00.00	339,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,477,300.00	112,572,358.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	14,149,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	14,149,958.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,477,300.00	98,422,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,477,300.00	98,422,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	114,859,439.86	179,011,223.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,859,439.86	179,011,223.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	109,831,774.31	178,551,893.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,899,392.82	50,062,557.60
210101	Үндсэн цалин	47,899,392.82	48,063,057.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,999,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,245,844.00	5,579,607.40
210201	Тэтгэврийн даатгал	4,245,844.00	3,732,043.10
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	466,586.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	417,660.50
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	97,958.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	865,359.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,890,285.83	17,068,223.16
210301	Гэрэл, цахилгаан	1,406,944.00	1,668,787.00
210302	Түлш, халаалт	9,617,665.83	13,931,670.16
210303	Цэвэр, бохир ус	1,865,676.00	1,467,766.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,283,263.01	10,566,722.00
210401	Бичиг хэрэг	531,000.00	513,000.00
210402	Тээвэр, шатахуун	233,750.01	1,338,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,763.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	334,150.00	8,715,032.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,120,600.00	00.00
2105	Нормативт зардал	13,166,399.00	28,368,012.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	538,150.00	802,300.00
210502	Хоол, хүнс	12,628,249.00	23,380,712.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	4,185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	114,060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	65,000.00
210604	Урсгал засвар	00.00	49,060.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,586,590.00	1,924,530.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,586,590.00	1,924,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,759,999.65	64,868,181.66
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	20,759,999.65	64,868,181.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,027,665.55	459,330.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	459,330.00

**Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	459,330.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,927,665.55	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,927,665.55	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,291,952,958.02	-5,386,580.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,300,694.38
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,300,694.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,300,694.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,291,952,958.02	-6,687,275.20

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	99,408,590.00	112,911,358.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	339,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	339,000.00
120009	Бусад орлого	00.00	339,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,408,590.00	112,572,358.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,931,290.00	14,149,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,931,290.00	14,149,958.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,477,300.00	98,422,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,477,300.00	98,422,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	99,408,590.00	112,911,358.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,408,590.00	112,911,358.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,380,924.45	112,452,028.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,731,900.00	49,256,558.00
210101	Үндсэн цалин	45,731,900.00	48,190,058.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,066,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,591,027.45	6,514,893.00
210201	Тэтгэврийн даатгал	2,591,027.45	5,560,594.70
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	159,920.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	226,822.90
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	47,715.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	519,840.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,890,270.00	14,468,223.00
210301	Гэрэл, цахилгаан	1,406,944.00	2,868,787.00
210302	Түлш, халаалт	11,617,650.00	10,131,670.00
210303	Цэвэр, бохир ус	1,865,676.00	1,467,766.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,767,513.00	3,376,490.00
210401	Бичиг хэрэг	421,000.00	366,500.00
210402	Тээвэр, шатахуун	294,250.00	1,338,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,763.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,988,500.00	1,671,300.00
2105	Нормативт зардал	21,735,964.00	23,310,034.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	258,150.00	302,300.00
210502	Хоол, хүнс	16,737,814.00	18,357,607.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,740,000.00	4,650,127.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	594,900.00	691,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	368,500.00	607,500.00
210604	Урсгал засвар	226,400.00	84,410.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,069,350.00	14,833,920.00

**Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,069,350.00	14,233,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,027,665.55	459,330.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	459,330.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	459,330.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,927,665.55	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,927,665.55	00.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,976,360.00	104,339,454.90	-21,086,213.70	110,229,601.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,976,360.00	104,339,454.90	-21,086,213.70	110,229,601.20
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,291,952,958.02	1,291,952,958.02
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,976,360.00	83,268,817.20	1,291,952,958.02	1,402,198,135.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,976,360.00	83,268,817.20	1,291,952,958.02	1,402,198,135.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	74,401,292.36	00.00	74,401,292.36
D08	Тайлант үеийн үр дүн	39,340,000.00	00.00	-6,687,275.20	32,652,724.80
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,316,360.00	157,670,109.56	1,285,265,682.82	1,509,252,152.38

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,477,200.00	90,411,574.45	98,422,400.00	98,079,108.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,477,200.00	90,411,574.45	98,422,400.00	98,079,108.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,477,200.00	88,311,574.45	98,422,400.00	98,079,108.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,731,900.00	45,731,900.00	49,256,600.00	49,256,558.00
210101	Үндсэн цалин	45,731,900.00	45,731,900.00	47,716,500.00	48,190,058.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	1,540,100.00	1,066,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,590,900.00	2,591,027.45	6,514,900.00	6,514,893.00
210201	Тэтгэврийн даатгал	2,590,900.00	2,591,027.45	4,456,800.00	5,560,594.70
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	278,300.00	159,920.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	506,200.00	226,822.90
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	244,000.00	47,715.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	1,029,600.00	519,840.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,921,700.00	14,890,270.00	14,470,400.00	14,468,223.00
210301	Гэрэл, цахилгаан	1,441,500.00	1,406,944.00	1,912,500.00	2,868,787.00
210302	Түлш, халаалт	11,617,700.00	11,617,650.00	11,120,900.00	10,131,670.00
210303	Цэвэр, бохир ус	1,862,500.00	1,865,676.00	1,437,000.00	1,467,766.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,779,100.00	2,747,913.00	3,376,500.00	3,376,490.00
210401	Бичиг хэрэг	422,400.00	421,000.00	307,400.00	366,500.00
210402	Тэвэр, шатахуун	323,700.00	294,250.00	917,700.00	1,338,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,200.00	44,163.00	215,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,988,800.00	1,988,500.00	1,936,000.00	1,671,300.00
2105	Нормативт зардал	21,739,200.00	21,737,164.00	23,311,400.00	23,310,034.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	258,200.00	258,150.00	366,300.00	302,300.00
210502	Хоол, хүнс	16,738,700.00	16,737,814.00	18,488,400.00	18,357,607.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,742,300.00	4,741,200.00	4,456,700.00	4,650,127.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	614,400.00	613,300.00	692,600.00	691,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	294,700.00	293,600.00	635,400.00	607,500.00
210604	Урсгал засвар	319,700.00	319,700.00	57,200.00	84,410.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	800,000.00	800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	200,000.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	600,000.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2100000.00	2100000.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	2,100,000.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,100,000.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	90,477,200.00	90,411,574.45	98,422,400.00	98,079,108.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	90,477,200.00	90,411,574.45	98,422,400.00	98,079,108.00

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	90,477,200.00	90,411,574.45	98,422,400.00	98,079,108.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	08.00	06.00	08.00	07.00
620001	Удирдах ажилтан	01.00	00.00	01.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	03.00	04.00	04.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	08.00	06.00	08.00	07.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	01.00	01.00	01.00	01.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	05.00	07.00	06.00